

ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ
“ГАН ХИЙЦ” ХК-НИЙ**

2023 оны 12 сарын 31-ний өдрийн санхүүгийн дуусвар тайлан

2024 он



ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Төмөрчний гудамж, Их найман шарга 10 давхар,
Утас: 9908-5151, 9199-1462, Факс: (976-11) 32-52-62,
E-mail: byambaahunnu@yahoo.com, http://www.dumaudit.mn

“ГАН ХИЙЦ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Д.ОЮУНЗУЛ, ТУЗ-ЫН
ДАРГА М.ДАВААСҮРЭН БОЛОН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НАРТ

2024.03.06 № 55
танай _____ -ны № _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлант

Зөрчилгүй санал дүгнэлт

“Ган хийц” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн билүүлсэн болно.

Аудитаар “Ган хийц” ХК -ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дунд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суuriйт хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитын ажлаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нелөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бид засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй аудитын хамрах цар хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар компаниас ирүүлсэн баримт материалын хүрээнд илэрсэн дутагдал, зөрчлийн талаарх асуудлыг зөвлөмжөөр удирдлагад танилцуулан хүргүүлсэн болно.

Тайлангийн хэрэглээний хязгаарлалт

Энэхүү аудиторын тайланг Компанийн тухай хуулийн 94.1, 95.1 дүгээр зүйлүүдэд заасны дагуу компанийн удирдлага, хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн. Бид уг тайлангийн агуулгын хүрээнд аливаа нэг гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

ДУНДМАНХАЙДАИ АУДИТ ХХК

УЛААНБААТАР ХОТ ЧД 2 ХОРОО

Огноо: 2023.03.04

